

*"Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6 дугаар хэсрэг*

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ**

2019.06.20

Улаанбаатар хот

Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ	Тасарсан болон удааширсан шалтгаан
1	2	3	4	5	6
<b>1.е.Засгийн газрын тогтоол</b>					
2018.08.22 № 258 Төрийн албаны сахилга, харуцлага, дэг журмыг чангатгах тухай	1.1.	Харьяа байгууллага болон салбар, нэгжид сахилга, дэг журмыг сахиулах тодорхой арга хэмжээ авч, төрийн албаны хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн төрийн албан хаагчид харуцлага тооцож тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байх	<p>Ажилтан, албан хаагчдын сахилга харуцлага, дэг журмыг чангатгах үүднээс тайлант хугацаанд дараах арга хэмжээг авч ажигллаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хөдөлмөрийн дотоод журмыг шинээр батлагдсан хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн шинэчлэн боловсруулсан.</li> <li>• Ёс зүйн дүрмийг "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-д нийцүүлэн шинэчлэн боловсрууллаа.</li> <li>• Газрын даргын зүгээс "Сахилга дэг журмыг чангатгаж, харуцлагыг өндөржүүлэх тухай" А/27 дугаар тушаал гаргаж, нийт ажилтан, албан хаагчдын сахилга, харуцлагыг өндөржүүлсэн.</li> <li>• Сахилга харуцлага алдсан, ёс зүйн зөрчил гаргасан ажилтан, албан хаагчдын зөрчлийн</li> </ul>	100%	

			<p>талаарх мэдээллийг нээлттэй хүлээн авахын сацуу үйлчилгээний ажиллагсдын ёс зүй, ажлын хариуцлагыг үнэлж, дүгнэх "Хяналтын хуудас" болон "Үнэлгээний карт"-ын системийг нэвтрүүлэн амжилттай хэрэгжүүлж байна.</p> <p>Төрийн албаны хууль тогтоомж, холбогдох дүрэм, журам, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн ажилтан, албан хаагчид хариуцлага тооцсон талаарх мэдээг дараах байдлаар эрх бүхий байгууллагад хүргүүлж байна:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолын хэрэгжилтийн тайланг улирал бүр, тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн мэдээг сар бүр НЗДТГ-ын ХШУХ-т;</li> <li>• Засгийн газрын 2019 оны 3 дугаар тэмдэглэлийн хэрэгжилтийн тайланг улирал бүр НЗДТГ-ын ХШУХ-т;</li> <li>• Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн мэдээг хагас бүтэн жилээр НЗДТГ-ын ТЗУХ-т.</li> </ul>		
1.2.	Иргэдийг ялгаварлан гадуурхахгүй ижил тэгш, зөв шударга харьцаж, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдлыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдөрт багтаан шийдвэрлэж, хариуг өгөх, цаашид өргөдөл, гомдлыг хугацаанд нь бодитой шийдвэрлэж	<p>2019 оны эхний хагас жилд нийт 84 өргөдөл ирснээс 81 өргөдлийг шийдвэрлэж, хариуг өргөдөл гаргагчид танилцуулсан ба 3 өргөдөл судлагдах шатанд байна.</p> <p>Тайланг хугацаанд өргөдөл гомдлыг хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн зөрчилгүй, өдөрт нь багтаан хүлээн аваагүй 1 зөрчил бүртгэгдсэн бөгөөд зөрчлийн үзүүлэлт өмнөх оны мөн үеэс 60 зөрчлөөр буюу 98,36 хувиар буурсан.</p> <p>Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2018 оны эхний хагас жилд 5 хоног 5 цаг 47 минут, сүүлийн хагас жилд 4 хоног 11 цаг 25 минут, 2019 оны</p>	100%		



	хэвшүүлэх	эхний хагас жилд 3 хоног 19 цаг 21 минут болж, өмнөх оны мөн үеэс 1 хоног, 46 цаг 26 минутаар буурсан байна. Хандаглтын хувьд 2018 оны эхний хагас жилд 120, сүүлийн хагас жилд 114 өргөдөл бүртгэгдсэн бол 2019 оны эхний хагас жилд 84 өргөдөл бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 36 өргөдлөөр буюу 30 хувиар буурчээ. Дээрх үр дүн нь ажиглан, албан хаагчаас ирүүлсэн санал хүсэлтийг тухай бүр хүлээн авч, түргэн шуурхай, үндэслэлтэй шийдвэрлэж буйтай холбоотой юм.		
1.3.	Төрийн албан хаагчдын ажлын Байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдгийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах	“Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний 3.1.1, “Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын төлөвлөгөө”-ний 1.1.1-д заасны дагуу ажлын байранд хяналт шинжилгээ хийж, газрын даргын 2019 оны А/24 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, Төрийн албаны зөвлөлд танилцуулж, санал авахаар бэлтгэл ажлыг бүрэн хангаад байна.	100%	
1.4.	Төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилгох замаар төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх	Байгууллагын мэргэжлийн албан хаагчийн сул орон тоог нөхөхдөө Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан чадахуйн /мерит/ болон шатлан дэвшүүлэх зарчмыг удирдлага болгон ажиллаж байна. Тайлант хугацаанд хүний нөөцийн менежер Г.Энхтуяаг захиргааны ахлах мэргэжилтнээр, байр хариуцсан менежер М.Алтантуяаг үйлчилгээний албаны даргаар, цахилгаанчин Б.Батсүрэнг цахилгааны инжөнөрээр, үйлчлэгч Г.Мөнхцэцэгийг зоогийн газрын кассаар, кофе шопын зөөгч Ц.Үрэлмааг хурлын заалгны зохион байгуулагчаар тус тус дэвшүүлэн ажиллаж байна. Энэхүү ажлын үр дүнд ажиглан, албан хаагчид идэвх	100%	

			санаачилгатай, тогтвор суурьшилтай ажиллах сэдэл бүрдэж буй нь 2018 оны эхний хагас жилд өөрийн санаачилгаар 33 ажилтан, албан хаагч ажлаас чөлөөлөгдсөн бол 2019 оны эхний хагас жилд байдлаар энэ үзүүлэлт 14 болж, өмнөх оны мөн үеэс 57,6 хувиар буурсан байна.		
	Төрийн жинхэнэ албан хаагч жирэмсний болон амаржсаны амралттай байгаа, эсхүл 3 сараас дээш хугацааны сургалтад хамрагдаж сул орон тоо гарснаас бусад тохиолдолд төрийн албаны сул орон тоонд гэрээт ажилтан томилохгүй байх зарчим баримталж, төрийн байгууллагад албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн богино хугацаагаар ажиллуулахаас бусад тохиолдолд гэрээт ажилтан ажиллуулахгүй байх	Төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг	Жирумсний болон амаржсаны амралттай байгаа 30 ажилтан албан хаагч, 3 сараас дээш хугацааны сургалтад хамрагдаж байгаа 1 албан хаагч, эрүүл мэндийн шалтгаанаар урт хугацааны чөлөөтэй байгаа 1 албан хаагч, нийт 32 ажилтан албан хаагчийн ажлын байрны сул тоонд мөн тооны ажилтан, албан хаагчийг хугацаатай хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулж буй бөгөөд гэрээт ажилтан ажиллуулдаггүй болно.	100%	
	1.7.	Төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг	Тайлант хугацаанд слесарь Ц.Батмөнхийн ажлын байранд архидан согтуурсан зөрчил гаргасан үйлдэлд сонсох ажиллагаа явуулсны үндсэн дээр газрын даргын Б/20 дугаар тушаалаар үүрэгт ажлаас нь чөлөөлсөн. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, ёс зүйн дүрэмд сахилга хариуцлагыг сайжруулах талаар нэмэлт заалт тусгаж, газрын даргын А/27 дугаар тушаал гарснаар ажилтан, албан хаагчдын ёс зүйн зөрчил эрс буурч, сахилга хариуцлага сайжирсан болно.	100%	



	Байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох		
1.8.	Төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах	Ажилтан, албан хаагчдын гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх чиглэлээр үе шаттай ажтууд хэрэгжүүлсний үр дүнд 2018 оны эхний хагас жилд 14 ажилтан ёс зүйн зөрчил гаргасан бол энэ тоо 2019 оны эхний хагас жилийн байдлаар 5 болж зөрчлийн мэдээ 64,2 хувиар буурсан байна.	100%
1.10.	Ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахаалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, зөрөг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах	Газрын хөдөлмөрийн дотоод журам болон ёс зүйн дүрэмд ажилтан, албан хаагчид бие биенээ ялгаварлан гадлуурхах байдлыг хориглосон зохицуулалт оруулж, уг үйлдлийг удаа дараа гаргасан ажилтан, албан хаагчид ажлаас чөлөөлөх хүртэл сахилгын шийтгэл ногдуулахаар тусгасан.	100%
3.	Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор гэнэтийн болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг холбогдох байгууллагатай хамтран төрийн байгууллагуудад тогтмол зохион байгуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг	Төлөвлөгөөний дагуу тайлант хугацаанд дараах хяналт шалгалтыг зохион байгууллаа. Үнд: <ul style="list-style-type: none"> <li>Бодлогын болон захирамжлалын баримт бичгийн хэрэгжилт;</li> <li>Газрын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт;</li> <li>НҮГ-ын 2018 оны ажилд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлт;</li> <li>Үйлчилгээний албаны үйл ажиллагаа;</li> </ul>	100%

		<p>эрхлэх газрын дарга Г.Занданшатарт, өөрийн эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллагад хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Байр ашиглалтын албаны үйл ажиллагаа;</li> <li>• Эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүлж буй үйл ажиллагаа;</li> <li>• ЗСХ-ийн нягтлан бодогч, нярвын үйл ажиллагаанд.</li> </ul> <p>Хяналт-шинжилгээний дүнг газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулан, илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, ажил сайжруулах хугацаатай үүрэг даалгаврыг холбогдох албан хаагчдад өгч ажилласан.</p>		
<p>2019.01.16 №23 2019 оныг "Иргэн төвтэй үйлчилгээний чанарын жил" болгон зарлах тухай</p>	<p>3</p>	<p>"Иргэн төвтэй үйлчилгээний чанарын жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг эрхлэх ажлын хүрээ, харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулж, ажлын тайланг улирал тутам Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.</p>	<p>"Иргэн төвтэй үйлчилгээний чанар"-ын жилийн хүрээнд манай байгууллага нь "Үйлчилгээний чанар-Байгууллагын соёл" сэдэвт нэг сарын хугацаатай болзолт уралдаан зохион байгууллаа. Болзолт уралдаанд нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн 3 салбар, нийслэлийн засаг захиргааны 5 байрны нийт 14 баг оролцож, төрийн албан хаагчдын ажиллах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор үзүүлж буй цэвэрлэгээ болон инженерийн байгууламжийн хэвийн ажиллагаа, хоол үйлдвэрлэлийн үйлчилгээг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан сайжруулах, чанаржуулах чиглэлээр шинэ санал, санаачилга дэвшүүлж хэрэгжүүлсэн байна.</p>	<p>100%</p>	
<p>2019.01.23 № 33 "Дүрэм батлах тухай"</p>	<p>2.</p>	<p>Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолоор баталсан дүрэмд нийцүүлэн баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт даалгасугай.</p>	<p>Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоол, 2019 оны 33 дугаар тогтоолд нийцүүлэн боловсруулж, газрын даргын А/21 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан. Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээний</p>	<p>100%</p>	



		Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан төлөвлөгөөнд тусгасан ажлын хүрээнд нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, эрхэлсэн салбар, харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжилтийг зохион байгуулж, тайланг хагас болон жилийн эцсийн байдлаар Аж үйлдвэржилтийн бодлогын зөвлөлд хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгосугай.	ажилтан болон бусад удирдах албан хаагчид хяналт тавьж ажиллаж байна.		
2019.01.30 № 59 2019 оныг "Эх оронч худалдан авалтын жил болгох тухай"	3.	Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан ажлын хүрээнд худалдан авч буй бараа бүтээгдэхүүний 70%-ийг эх орны үйлдвэрийн хүнс болон бараа бүтээгдэхүүн эзэлж байна.	100%		

Хэсгийн дундаж: 100 хувь

1.ж.Засгийн газрын хуралдааны тэмдэглэл

1	2	3	4	5	6
2019.01.16 № 03-1 Монгол улсын Засгийн газраас зарласан "Хариуцлагын жил"-ийн хүрээнд зохион байгуулсан ажлын	2	Төрийн болон орон нутгийн удирдлагын бүх шатны байгууллагууд баталсан дүрэм, журамдаа шинжилгээ хийж, иргэд, олон нийтээр хэлэлцүүлэн, байгууллага, иргэдэд хүнд суртал, чирэгдэл үүсгэж байгаа дүрэм журмыг хүчингүй болгох арга хэмжээ авч, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт мэдээг хагас, бүтэн	Дараах журам, стандартыг шинээр батлагдсан хууль тогтоомж, дүрэм журам, тогтоол шийдвэрт нийцүүлэн шинэчлэн боловсрууллаа. Үнд: <ul style="list-style-type: none"> <li>Хөдөлмөрийн дотоод журам;</li> <li>Байгууллагын ёс зүйн дүрэм;</li> <li>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага;</li> <li>Ажлын байрны цэвэрлэгээ, үйлчилгээний ерөнхий шаардлага;</li> <li>Хоол, цайны үйлчилгээнд тавигдах ерөнхий</li> </ul>	100%	

Тайлангийн талаар	Жилээр ирүүлэх			
3	Төрийн байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлээгүй төрийн албан хаагч, албан тушаалтанд харилцлага тооцож, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн мэдээнд тусгаж байх	<p>Тайлант хугацаанд өргөдөл гомдлыг хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн зөрчилгүй, өдөрт нь багтаан хүлээн аваагүй 1 зөрчил бүртгэгдсэнээр зөрчлийн үзүүлэлт өмнөх оны төлөө үеэс 60 зөрчлөөр буюу 98,36%-иар буурсан байна.</p> <p>Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацааг өмнөх үетэй харьцуулахад:</p> <ul style="list-style-type: none"> <li>• 2018 оны эхний хагас жилд 5 хоног 5 цаг 47 минут;</li> <li>• 2018 оны сүүлийн хагас жилд 4 хоног 11 цаг 25 минут;</li> <li>• 2019 оны эхний хагас жилд 3 хоног 19 цаг 21 минут.</li> </ul>	100%	
4	Төрийн албан хаагч ажлын болон	Тайлант хугацаанд ажлын байранд архидан	100%	



		<p>ажлын бус цагаар ажлын байр, томилолтын явцад согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох талаар тогтоосон дэг журмыг чанд мөрдүүлэх, журмыг зөрчсөн албан хаагчтай тухай бүр холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцагаа тооцож байх</p>	<p>согтуурсан 1 зөрчлийг байгууллагын ёс зүйн зөвлөлийн 2019.02.14-ний өдрийн 01 дүгээр хурлаар хэлэлцүүлж, газрын даргын 2019.02.15-ны өдрийн Б/20 дугаар тушаалаар слесарь Ц.Батмөнхийг үүрэгт ажлаас нь чөлөөлсөн болно.</p>		
5.		<p>Дам, агентлагийн бодлого, шийдвэрийг бусад байгууллага болон олон нийтэд ил тод мэдээлэх, тусгай зөвшөөрөл олгох ажлыг цахимжуулах арга хэмжээ авах</p>	<p>Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилт, ажлын тайлан мэдээ, газрын хэмжээнд хэрэгжиж буй дүрэм журам, заавар стандарт, худалдан авах ажиллагааны талаарх тайлан мэдээ, урилга, хүний нөөцийн талаарх мэдээлэл, газрын даргын баталсан тушаал, зэргийг <a href="http://www.khangardi.mn">www.khangardi.mn</a> цахим хуудсанд тухай бүр байршуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд байгууллагаас зохион байгуулсан, хамтран зохион байгуулсан, хамрагдсан үйл ажиллагааны талаарх 43 төрлийн мэдээ, мэдээллийг <a href="http://www.khangardi.mn">www.khangardi.mn</a> цахим хуудсанд байршуулсан болно. Тус газар нь төрийн албан хаагчдын ажиллах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэх үндсэн чиг үүрэг бүхий байгууллага бөгөөд ямар нэгэн тусгай зөвшөөрөл олгодоггүй болно.</p>	100%	
6.		<p>Төрийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийцүүлэн төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг сар бүр дүгнэж ажиллаж</p>	<p>Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүнд мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-д нийцүүлэн албан хаагчдын ажлын</p>	90%	Хэрэгжилт тооцох хугацаа болгоогүй

			<p>төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр, ажлын дэлгэрэнгүй тайланг хагас жилээр хүлээн авсан бөгөөд үнэлж дүгнэх ажлыг хэрэгжүүлж байна.</p>		
			<p>Хэрэглэгчийн үнэлгээг тогтоох, санал асуулга, судалгаа явуулах, цаасан хэрэглээг багасгах, цаг хугацааг хэмнэх зорилгоор Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын систем /ERP/-ээр буюу цахим хэлбэрээр судалгаа авах шинэ нөхцөлийг бий болгохоор нийслэлийн Мэдээлэл, технологийн газар, Ухаалаг шийдэл ХХК-тай хамтран системд хөгжүүлэлт хийж ажиллаа. ННҮГ-ийн үндсэн чиг үүргийн хэрэгжилтэд хэрэглэгчийн үнэлгээг тогтоох зорилгоор нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас 2019.05.30-ны өдрөөс 2019.06.06-ны өдрүүдэд 12 асуултын хүрээнд сэтгэл ханамжийн судалгааг явуулсан.</p>	100%	
7.	<p>Төрийн бүх шатны байгууллагын салбар, нэгжийн ажлын уялдаа, бүтээмжийн үнэлгээг тодорхой болгох</p>		<p>Уг судалгаанд нийслэлийн засаг захиргааны байруудад байрлан үйл ажиллагаа явуулж байгаа нутгийн захиргааны 31 байгууллагын 707 ажилтан, албан хаагч оролцож, санал хүсэлтээ ирүүлсэн байна.</p>		
8	<p>Төрийн албан хаагчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг хууль хяналтын байгууллагатай хамтран зохион байгуулах, хууль зөрчсөн албан хаагчдад заавал хариуцлага тооцож байх</p>	<p>Нийтлэг үйлчилгээний газрын “2019 оны сургалт, нийгмийн баталгааг хангах чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө”-ний хүрээнд мэргэжлийн байгууллагуудтай хамтран дараах сургалтыг зохион байгуулж, ажиглан, албан хаагчдыг хамрууллаа. Үнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>Төрийн албаны зөвлөлтэй хамтран “Төрийн албаны тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын талаар мэдээлэл өгөх сургалтад Захиргаа, санхүүгийн албан хаагчид;</li> <li>“Төгс Баян Хүрээ” ХХК-тай хамтран зохион</li> </ul>	100%		



			<p>байгуулсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад нийт ажилтан, албан хаагчид;</p> <ul style="list-style-type: none"> <li>• Нийслэлийн Онцгой байдлын газраас зохион байгуулсан "Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоо, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ" сэдэвт сургалтад нийт ажилтан, албан хаагчид.</li> </ul> <p>Төрийн албан хаагчидтай шууд харилцдаг үйлчилгээний болон инженер техникийн ажилтнуудын ажлын чанар, ёс зүйг үнэлж дүгнэх зорилгоор "Хяналтын хуудас" болон "Үнэлгээний карт"-ын системийг нэвтрүүлж, амжилттай хэрэгжүүлж байна. Түүнчлэн хэрэглэгчийн үнэлгээг тогтоох зорилгоор зохион байгуулсан сэтгэл ханамжийн судалгаанд нутгийн захиргааны 31 байгууллагын 707 ажилтан, албан хаагч оролцож, санал хүсэлтээ ирүүлсэн бөгөөд судалгаанд оролцогчдын 64% нь сайн, 28% нь дунд, 8% нь хангалтгүй үнэлгээ өгсөн. Дүнг дарлын дэргэдэх зөвлөлийн 7-р хурлаар хэлэлцэж байр тус бүрд гарсан санал хүсэлтийг хэрэгжүүлж ажиллах үүргийг холбогдох албан хаагчдад өгсөн.</p>	100%	
<p>2019.01.16 № 03 – II Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг улсын хэмжээнд</p>	1.2	<p>Төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилгох, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоог нөхөхдөө чадахуйн /мерит/ болон шатлан дэвшүүлэх зарчмыг үндсэн шалгуур болгон Төрийн албаны тухай хуулийг чанд баримтлах</p>	<p>Байгууллагын мэргэжлийн албан хаагчийн сул орон тоог нөхөхдөө чадахуйн /мерит/ болон шатлан дэвшүүлэх зарчмыг үндсэн шалгуур болгон ажиллаж, тайлант хугацаанд байр харьцсан менежер М.Алтантуяаг үйлчилгээний албаны даргаар, цахилгаанчин Б.Батсүрэнг цахилгааны инженерээр, мөн хүний нөөцийн менежер Г.Энхтуяаг захиргааны ахлах мэргэжилтнээр, үйлчлэгч Г.Мөнхцэцэгийг зоолийн газрын кассаар, кофе шолын зөөгч</p>	100%	

<p>ЗОХИОН Байгуулсан дүнгийн тухай</p>		<p>Ц.Үрэлмааг хурлын заалны зохион байгуулагчаар тус тус дэвшүүлэн ажиллуулж байна.</p>		
<p>1.5</p>	<p>Төрийн захиргааны байгууллагын ашиглаж байгаа компьютер, техник хэрэгслийн элэгдлийг тооцон шинэчлэх арга хэмжээг батлагдсан төсвийн багцдаа багтаан үе шаттайгаар хэрэгжүүлэх</p>	<p>Ажилтан, албан хаагчдын хэрэглэж буй компьютер, техник хэрэгслийн элэгдлийг холбогдох журмын дагуу тооцон, актлах хугацаа болсон хөрөнгийг Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлын шийдвэрээр актгалан тохиолдолд тэдгээрийг шинэчлэх арга хэмжээг батлагдсан төсвийн багцдаа багтаан үе шаттай хэрэгжүүлж ажиллана.</p>	<p>100%</p>	
<p>1.6.</p>	<p>Төрийн байгууллагын үйл ажиллагаанд ажлын байрны зураг авалт хийсний үндсэн дээр боломжит үйл ажиллагааг цахимжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах</p>	<p>Байгууллагаас зохион байгуулж буй үйл ажиллагаа, сургалт мэдээллийн цаг, оролцсон, хамрагдсан, хамтран ажилласан арга хэмжээний талаарх мэдээллийг тухай бүр зуражруулан баримтжуулж, холбогдох мэдээллийн хамт <a href="http://www.khanbandi.mn">www.khanbandi.mn</a> цахим хуудсанд байршуулан, ил тод байдлыг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд 5 төрлийн 43 мэдээг байгууллагын цахим хуудсанд багцдаа байршуулжээ.</p>	<p>100%</p>	
<p>1.7.</p>	<p>Төрийн албаны хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнийг мэргэшүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах</p>	<p>Батлагдсан төлөвлөгөөний дагуу хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтныг дараах сургалтуудад хамрууллаа. Үнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• “Төрийн албаны тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын талаар;</li> <li>• Баримт бичиг боловсруулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн талаар;</li> </ul> <p>Цаашид хүний нөөцийн чиглэлээр мэргэшүүлэх чиглэлээр сургалтад үе шаттай хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.</p>	<p>100%</p>	
<p>1.8.</p>	<p>Төрийн бүх шатны албан хаагчийг хамруулах сургалтын хуваарийг</p>	<p>“Нийтлэг үйлчилгээний газрын 2019 оны сургалт, нийгмийн багалгааг хангах чиглэлээр хийх ажлын</p>	<p>100%</p>	



		<p>жил бүрийн 1 дүгээр сард багтаан төлөвлөх, албан хаагчдыг сургалтад хамруулах, хэрэгцээ шаардлага, үр дүн нь тодорхой бус сургалтад оролцуулахаас татгалзах</p>	<p>төлөвлөгөө"-ний дагуу эхний хагас жилд дараах сургалтыг мэргэжлийн байгууллага, албан хаагчидтай хамтран зохион байгуулж, ажиглан, албан хаагчдыг хамрууллаа. Үнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• "Хувь хүний хөгжил" "Ажлын цаг ашиглалт", "Ажлын төлөвлөлт", "Ажлын байрны сэтгэл зүй, эмх цэгц" сэдэвт сургалтад 40 гаруй үйлчилгээний ажигтнууд;</li> <li>• Төр Засгийн үйлчилгээ эрхлэх газраас зохион байгуулсан үйлчилгээний ажигтны мэргэжил, мэргэжлийн зэрэг, үнэмлэх олгох онол, практикын сургалтад 20 ажигтан;</li> <li>• Зоогийн газрын үйлчилгээг чанаржуулах, ажигтан, албан хаагчдыг чадваржуулах зорилгоор Монголын зочид буудлын холбоотой хамтран зөөгчийн ур чадвар дээшлүүлэх сургалтад 22 ажигтныг;</li> <li>• Монголын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний мэргэжлийн боловсролын академийн "Эрүүл ахуйн зохистой дадал", "Үйлдвэрлэлийн зохистой дадал" сэдэвт сургалтад үйлчилгээний 20 ажигтан;</li> <li>• Нийслэлийн Архивын газрын "Баримт бичиг боловсруулалт, албан хэрэг хөтлөлтийн стандарт" сэдвээр зохион байгуулсан сургалтад захиргаа, санхүүгийн хэлтсийн 37 албан хаагч;</li> <li>• Үйлчилгээний ажиглагсдын дунд байгууллагын соёлыг төлөвшүүлэх, идэвхжүүлэх, хувь хүний хөгжлийг дэмжих зорилгоор "Байгууллагын соёл, ажигтны харилцаа, хандлага" сэдэвт сургалт зохион байгуулж, 30 гаруй ажигтан, албан хаагчдыг;</li> <li>• "Удирдахуйн ухаан" сургалтад байр харуулсан 8 менежер тус тус хамрагдлаа.</li> </ul>	
--	--	--	--	--

	1.9.	Төрийн албаны тухай хууль, холбогдох журамд заасны дагуу төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээг бодитой, үнэн зөв үнэлэх, үнэлгээний дагуу цалин урамшуулал, хариуцлагын асуудлыг хууль, дүрэм журамд нийцүүлэн хэрэгжүүлж байх	Ажилтан, албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн үнэлж, цалин урамшуулал, хариуцлагын асуудлыг шийдвэрлэж байна. Ажилтан, албан хаагчдын ажлын үнэлгээг улирал бүр байгууллагын <a href="http://www.khanqardi.mn">www.khanqardi.mn</a> цахим хуудсанд байршуулан ил тод байдлыг ханган ажиглаж буй болно.	100%	
	1.10.	Төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг бодлогын баримт бичигтэй уялдуулах, хагас, бүтэн жилээр явцын хяналт шинжилгээ хийж үр дүнг албан хаагчдад тогтмол мэдээлж байх	“Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын 2019 оны ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний дагуу байгууллагын төлөвлөгөөний 2019 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, 2019.06.20-ны өдөр газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Байгууллагын төлөвлөгөөний хэрэгжилтийн мэдээг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт тухай бүр байршуулж байна.	100%	
	1.11.	Төрийн албан хаагчийн сахилга хариуцлагыг дээшлүүлэн байгууллага, нутаг дэвсгэртээ хууль хэлбэрэлтгүй хэрэгждэг соёлыг тогтоож, иргэдийн итгэлийг хүлээсэн, ил тод, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэх чиглэлээр өөрийн эрх хэмжээний хүрээнд үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулж, хэвшүүлэх	“Иргэн төвтэй үйлчилгээний чанар”-ын жилийн хүрээнд манай байгууллага нь “Үйлчилгээний чанар-Байгууллагын соёл” сэдэвт болзолт уралдааныг нэг сарын хугацаатай зохион байгууллаа. Болзолт уралдаанд нийслэлийн засаг захиргааны 5 байр, нийслэлийн үйлчилгээний 3 төвийн 14 баг оролцож, төрийн албан хаагчдын ажиглах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор үзүүлж буй цэвэрлэгээ болон инженерийн байгууламжийн хэвийн ажигллага, хоол үйлдвэрлэлийн үйлчилгээг сайжруулах, чанаржуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр шинэ санал, санаачилга дэвшүүлж хэрэгжүүлэн, өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан	100%	



		нийслэлийн засаг захиргааны байруудыг тохижуулах ажлыг хийж гүйцэтгэлээ.		
Хэсгийн дундаж: 99,3 хувь				
Нийт дундаж: 99,68 хувь				

ХЯНАЖ, ТАНИЛЦСАН  
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА 

ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН  Т.ИТГЭЛ

ТАЙЛАН ГАРГАСАН:  
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН  
ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АЖИЛТАН  Э.ХОРОЛДУЛАМ